

Батлав.

БОАЖЯ-ны ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА:

_____ / _____ /

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

ОДОД ГОУЛД ХХК-ийн захирал

_____ / Л.МӨНХБАЯР /

***БАЯНХОНГОР АЙМГИЙН БӨМБӨГӨР, БУУЦАГААН СУМЫН НУТАГТ
ОРШИХ БАЙДРАГИЙН ЦАГААН ТОХОЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН
2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН***

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: **MV-004960, MV-007468**/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР **5180252** /

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын ахлах мэргэжилтэн _____ / _____ /

Боловсруулсан:

ОДОД ГОУЛД ХХК-ийн геологич _____ /Т. ГАНСҮХ/

2022 он

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	2
1.2. Төслийн талбайн байршил.....	2
ХОЁР. 2022 ОНД ХИЙГДСЭН УУЛЫН АЖИЛ.....	5
2.1. Үйлдвэрлэлийн хүчин чадал, ажиллах горим.....	5
2.2. Олоборлолтын техник тоног төхөөрөмжийн жагсаалт.....	6
2.3. Ашиглалтын систем.....	6
2.4. Уурхайн тээвэр.....	7
2.5. Уурхайн усан хангамж.....	7
ГУРАВ. БАЯЖУУЛАЛТ.....	9
3.1. Баяжуулалтын технологийн горим.....	9
3.2. Шлюзэн дээрх баяжуулалт.....	11
3.3. Гүйцээн баяжуулах дамжлага.....	12
ДӨРӨВ. УУРХАЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖ.....	12
ТАВ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	12
5.1. Газрын гадаргад нөлөөлөх гол сөрөг нөлөөлөл.....	13
5.2. Агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөлөл.....	14
5.3. Усан орчинд нөлөөлөх сөрөг нөлөөлөл.....	16
5.4. Ургамлын нөмрөгт нөлөөлөх гол сөрөг нөлөөлөл.....	17
5.5. Амьтаны аймагт нөлөөлөх гол сөрөг нөлөөлөл.....	17
ЗУРГАА. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ.....	18
ДОЛОО.НӨХӨН СЭРГЭЭЛТ.....	22
НАЙМ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭНИЙ БИЕЛЭЛТ.....	22
ЕС. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭНИЙ БИЕЛЭЛТ.....	23
АРАВ. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ.....	23
АРВАН НЭГ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТ.....	23
АРВАН ХОЁР. ОСОЛ ЭРСДЭЛ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТ.....	24
АРВАН ГУРАВ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ.....	25
АРВАН ДӨРӨВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	25

НЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:	“Байдрагийн цагаан тохой” нэртэй газар байрлах MV-004960 тусгай зөвшөөрөлтэй алтны шороон орд ашиглах
Төсөл хэрэгжүүлэгч:	Гадаадын хөрөнгө оруулалттай “Ододгоулд” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9019086077, Регистрийн дугаар: 5180252, Захирал: Лхаасүрэн овогтой Мөнхбаяр
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Баянхонгор аймаг, Бөмбөгөр сум, 1-р баг, Улаан сайр, Утас: 312483
Төслийн байршил:	“Байдрагийн цагаан тохой” нэртэй газар байрлах MV-004960 тусгай зөвшөөрөлтэй алтны шороон орд нь Баянхонгор аймгийн Бөмбөгөр сум, Бууцагаан сумын нутагт оршино. Тус ордууд нь Улаанбаатар хотоос 750 км, Баянхонгор сумын баруун хойно 130 км, Бөмбөгөр сумын төвөөс баруун хойно 28 км, Бууцагаан сумын төвөөс зүүн хойно 60 км зайд байрлана.

1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Аж ахуйн нэгжийн нэр	Одод гоулд” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9019086077
Регистрийн дугаар	5180252
Улсад бүртгүүлсэн	2007.11.20
Үйл ажиллагааны чиглэл	Гадаад худалдаа
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл	MV-007468, MV-004960
Хаяг	Баянхонгор Бөмбөгөр сум, Улаан сайр 1-р баг
Утас	11-312483

Хүснэгт №1. Ерөнхий мэдээлэл


1.3. Төслийн байршил

“Байдрагийн цагаан тохой” нэртэй газар байрлах MV-004960 тусгай зөвшөөрөлтэй алтны шороон орд нь Баянхонгор аймгийн Бөмбөгөр сум, Бууцагаан сумын нутагт оршино. Тус ордууд нь Улаанбаатар хотоос 750 км, Баянхонгор сумын баруун хойно 130 км, Бөмбөгөр сумын төвөөс баруун хойно 28 км, Бууцагаан сумын төвөөс зүүн хойно 60 км зайд байрлана.

Д/д	Лицензийн дугаар	Газарзүйн солбицол		Тэгш өнцөгтийн солбицол	
1	MV-004960	99° 22' 10.440"	46° 16' 21.570"	528476	5124409
2		99° 22' 10.440"	46° 16' 16.730"	528476	5124259
3		99° 22' 5.480"	46° 16' 21.510"	528369	5124406
4		99° 21' 53.720"	46° 16' 21.510"	528118	5124405
5		99° 22' 3.160"	46° 16' 16.470"	528320	5124251
6		99° 22' 8.020"	46° 16' 3.080"	528426	5123838
7		99° 22' 5.090"	46° 15' 55.350"	528365	5123599
8		99° 22' 2.320"	46° 15' 53.650"	528306	5123546
9		99° 21' 51.560"	46° 15' 53.860"	528075	5123552
10		99° 21' 41.840"	46° 15' 51.010"	527868	5123463
11		99° 21' 37.050"	46° 15' 52.200"	527765	5123499
12		99° 21' 25.630"	46° 15' 52.490"	527520	5123507
13		99° 21' 12.450"	46° 15' 56.840"	527238	5123640
14		99° 21' 6.190"	46° 15' 57.800"	527104	5123669
15		99° 20' 59.050"	46° 15' 47.590"	526952	5123353
16		99° 21' 7.100"	46° 15' 47.590"	527124	5123354
17		99° 21' 10.110"	46° 15' 52.500"	527188	5123506
18		99° 21' 20.150"	46° 15' 48.140"	527404	5123372
19		99° 21' 30.860"	46° 15' 48.190"	527633	5123375
20		99° 21' 32.020"	46° 15' 47.590"	527658	5123356
21		99° 21' 46.160"	46° 15' 47.590"	527961	5123358
22		99° 21' 52.850"	46° 15' 49.210"	528104	5123408
23		99° 21' 57.730"	46° 15' 48.430"	528208	5123385
24		99° 22' 6.750"	46° 15' 50.020"	528401	5123435
25		99° 22' 10.440"	46° 15' 53.450"	528480	5123541
26		99° 22' 10.440"	46° 15' 47.560"	528480	5123359
27		99° 20' 40.430"	46° 15' 47.560"	526554	5123350
28		99° 20' 40.430"	46° 16' 21.570"	526549	5124400
1	MV-007468	99° 19' 48.58"	46° 14' 37.09"	528476	5124409
2		99° 19' 43.73"	46° 14' 36.58"	528476	5124259
3		99° 19' 59.29"	46° 14' 36.58"	528369	5124406
4		99° 20' 10.4"	46° 14' 44.94"	528118	5124405
5		99° 20' 10.4"	46° 14' 51.61"	528320	5124251
6		99° 20' 16.46"	46° 14' 51.61"	528426	5123838
7		99° 20' 18.28"	46° 14' 55.37"	528365	5123599
8		99° 20' 17.76"	46° 15' 2.61"	528306	5123546
9		99° 20' 24.37"	46° 15' 4.68"	528075	5123552
10		99° 20' 28.86"	46° 15' 6.79"	527868	5123463
11		99° 20' 33.61"	46° 15' 5.98"	527765	5123499
12		99° 20' 39.24"	46° 15' 5.65"	527520	5123507
13		99° 20' 40.43"	46° 15' 4.2"	527238	5123640
14		99° 20' 40.43"	46° 14' 51.58"	527104	5123669
15		99° 20' 10.44"	46° 14' 51.58"	526952	5123353

16		99° 20' 10.44"	46° 14' 36.56"	527124	5123354
17		99° 19' 30.44"	46° 14' 36.56"	527188	5123506
18		99° 19' 30.44"	46° 14' 51.57"	527404	5123372
19		99° 19' 50.43"	46° 14' 51.57"	527633	5123375
20		99° 19' 50.43"	46° 14' 51.58"	527658	5123356
21		99° 19' 50.43"	46° 14' 51.58"	527961	5123358
22		99° 19' 50.43"	46° 15' 8.56"	528104	5123408
23		99° 20' 20.19"	46° 15' 8.56"	528208	5123385
24		99° 20' 14"	46° 15' 6.33"	528401	5123435
25		99° 20' 8.61"	46° 15' 2.43"	528480	5123541
26		99° 20' 11.12"	46° 14' 57.42"	528480	5123359
27		99° 20' 9.19"	46° 14' 52.62"	526554	5123350
28		99° 19' 56.32"	46° 14' 41.16"	526554	5123350

Хүснэгт №2. MV-004960 тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбилцол



Зураг № 1. MV-004960 тусгай зөвшөөрөлтэй талбайн байршилн зураг



Зураг №2. MV-004960 тусгай зөвшөөрөлтэй талбайн ерөнхий байдал


ХОЁР. 2022 ОНД ХИЙГДСЭН УУЛЫН АЖИЛ

2.1. Үйлдвэрлэлий хүчин чадал ажиллах горим

MV-004960 талбайд 2022 онд 1-С, 1-В, 2-В, 3-В, 4-В, 2-С, 3-С блокуудад 576.56 мян.м³ хөрс хуулж, 191.86 мян.м³ элс олборлож хими цэврээр 63.68 кг алт авахаар төлөвлөгөө батлуулсан.

2022 оны 5 сарын 15-аас ашиглалтын үйл ажиллагаа төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу MV-004960 тоот тусгай зөвшөөрөл бүхий талбайн В'-2 блокоос хөрс хуулалт, элс олборлолтын ажил эхлүүлсэн бөгөөд 2022.05.15-2022.05. 28 болон 2022.07.05-2022.07.13-г хүртэл нийт 21 хоног ашиглалтын үйл ажиллагаа явагдаж тодорхой шалтгааны улмаас үйл ажиллагаа зогссон.

Нийт ашиглалтын хугацаанд MV-004960 тоот тусгай зөвшөөрөл бүхий талбайн В'-2, В'-3 блокуудад 1.9 га талбайгаас нийт 17.1 мян.м.куб элс олборлон угааж тус талбайдаа техникийн нөхөн сэргээлт хийсэн. Ил аргаар ашиглалт явуулах үед хуулсан хөрсний зузаан дунджаар 4.5 – 5.5 м, ашигт давхаргын зузаан 0.9м байв.



Зураг №3. 2022 онд ашиглалт явуулсан талбайн зураг

2.2. 2022 оны олборлолтонд ашигласан техник тоног төхөөрөмж, хүчин чадал

Тоног төхөөрөмж	Марк	Тоо
<i>Уулын хэсэг</i>		
Экскаватор	Hyundai 520	1
Экскаватор	Hyundai 3000	1
Экскаватор	Hyundai 220	1
Утгуурт ачигч	Liugong ZL-50	1
Авто самосвал	North-benz	2
<i>Баяжуулах хэсэг</i>		
Скруббер	NZMS80BE	1
Насос	K-50	1
Дизель генератор	KC70GF	1
Дизель генератор	KC20	1

Хүснэгт №3. Үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт

2.3. Ашиглалтын систем

Ордын элсний давхрагын өргөн 220 м хүртэл, хөрсний зузаан бага 4.5 – 5.5 м, хөрс хуулалтын коэффициент харьцангуй бага, баяжуулах төхөөрөмжийг уурхайн ухштай ойрхон

байрлуулж ашигласан учир ордын хөрс хуулалтыг дотоод овоолготой ашиглалтын системээр ашиглалт явуулсан.

Ил уурхайд ашиглалтын үйл ажиллагааг явуулахдаа тухайн ашиглалтын блокийг эксковаторын сумны сунах урт, хөрс хуулалтын гүнээс хамаарч ойролцоогоор 10 -12 м – ийн өргөнтэй хөрс хуулалт хийж, уг хөрс хуулсан талбайн элсийг угаан баяжуулах төхөөрөмжрүү зөөж дууссаны дараа дараагийн хэсэгшилийн хөрсийг хуулж баяжуулалтад бэлдэх замаар ашиглалт явуулсан.

Ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн талбайн шимт хөрсийг 20 см зузаантайгаар эксковатор, хутгуурт ачигч ашиглан хуулж шимт хөрсний овоолгыг ашиглалтанд өртөж байгаа талбайн захад байршуулан, тухайн хэсгийг ашиглаж дууссаны дараа дараагийн хэсэгшлээс гарсан хөрсөөр дүүргэлт хийн тухай бүрд нь шимт хөрсийг тараан байршуулж ажилласан.

2.4. Уурхайн тээвэр

2022 оны ашиглалтын үйл ажиллагаанд NorthBenz маркийн 18м³ багтаамжтай авто самосвал 2ш - ийг ашигласан бөгөөд угаах төхөөрөмжрүү баяжмал тээвэрлэхэд ашигласан. Тухайн онд MV-004960 тоот тусгай зөвшөөрлийн талбайгаас нийт 17100 м³ элсийг угаах төхөөрөмжрүү тээвэрлэсэн.

Ордыг ашиглахдаа хөрс хуулалтыг дотоод овоолгоор, хөрс хуулалтанд тээвэрлэлт ашиглахгүй систем сонгосон тул тээвэр зөвхөн карьераас угаах төхөөрөмжрүү элс зөөх ажил хийгдсэн бөгөөд тээвэрлэлтийн дундаж зай 200м байв.



Зураг №4. 2022 оны тээвэрлэлтэнд ашигласан авто самосвал

2.5. Уурхайн ус таталт, усан хангамж

Ил уурхайн ус таталт: Ашиглалт явуулах талбайн хувьд дөрөвдөгчийн бэл, хормойн

гаралтай сэвсгэр хурдас дахь жигд бус тархалттай газрын доорх ус оршино. Ордын дэнжийн хэсэгт усгүй хуурай, татмын хэсэгт ус агуулагч давхрага нь алт агуулж буй элсний давхрага, давхрагын дундаж зузаан нь 1.0м, хайгуулын талбайн хэмжээнд шүүрлийн усны тархалт жигд бус, дундаж ундрага нь 0.2 л/с, усны хатуулаг нь 2.7 мг.экв/л байгааг хайгуулын ажлын үеэр хийгдсэн цооног, шурфийн шавхалтаар тогтоосон байна. Шүүрлийн усны хэмжээ нь тухайн жилийн хур тундасын хэмжээнээс хамаарч өөрчлөгдөнө. 2022 оны хувьд уурхай орчимд хур тунадас бага орсон улмаас байдраг голын усны түвшин бага байсан тул ашиглалт явуулсан карьерт шүүрлийн усны хэмжээ маш бага байсан.



Зураг №5. Ус таталт. /Байдраг голоос цэврийн нуур/

	Насосны марк		K150-125-315
1	Хүчин чадал	м ³ /ц	200
2	Түрэлт		32
3	Чадал	кВт	30
4	Сорох хоолойн сорох өндөр	м	4
5	Эргэлтийн хурд	эрг/мин	1450
6	Хөдөлгүүрийн марк		Y280S-2
7	Жин	Кг	161

Хүснэгт №4. K150-125-315 насосын үзүүлэлт



Зураг №6. Ус таталт. /Цэврийн нуурнаас угаах төхөөрөмжрүү/

Технологийн усны хэрэглээ: 2022 онд баяжуулах үйлдвэрийн хэрэглээний усыг гадаргын усаар хангаж ажилласан. Баяжуулах үйлдвэрт хоногт дунджаар 814 м^3 элсийг угаан баяжуулсан ба нийт 17100 м^3 элс угаан баяжуулсан.

1 м^3 элсийг угаан баяжуулахад 3 м^3 ус хэрэглэсэн гэж үзвэл (Техник эдийн засгийн үндэслэлд 1 м^3 элсийг 2.8 м^3 ус хэрэглэгдэх тооцоо гарсан):

$$17100 \text{ м}^3 * 3 \text{ м}^3 = 51300 \text{ м}^3$$

Тухайн жил хур тунадас болон гадаргын усны хэмжээ бага байсантай холбоотойгоор шүүрлийн усыг шавхан зайлуулалт хийх шаардлагагүй байсан ба угаах төхөөрөмжинд хэрэглэгдэх нуурын ус болон сэлбэлтийн усыг байдрагийн голоос татаж хэрэглэсэн. Усан сангаас гарсан усны 70 хүртэлх хувийг дахин ашигласан.


ГУРАВ. БАЯЖУУЛАЛТ

3.1. Баяжуулалтын технологийн горим

Байдрагийн цагаан тохойн алтны шороон ордыг угаан баяжуулах технологийг сонгохдоо технологийн туршилтын үр дүн болон эдийн засгийн үр ашгийг бодолцон үзэж алт агуулсан элсний бул чулуу, хайргыг NZMS80BE маркийн скруббер, гүйцээн баяжуулалтыг жижиг бутар ашиглан угааж, ангилсан.

Элсний угаагдах чанар нь хөнгөн бөгөөд дунд, жижиг ширхэгтэй алт агуулсан орд газар тул шлюзийн боловсронгуй технологийг хэрэглэх нь илүү үр дүнтэй ба уг төхөөрөмж нь шаврыг угаах, элсийг ангилах тал дээр илүү үр дүнтэй байсан.

Дараах зурагт үзүүлсэн схемийн дагуу баяжуулалт болон гүйцээн баяжуулах ажил хийгдсэн.



Зураг №6. Алттай элсийг баяжуулах технологи

№	Төхөөрөмжийн үзүүлэлт	Хэмж их нэгж	Тоон утга	
1	Хүчин чадал	м ³ /ц	80	
2	Түлш зарцуулалт 12цагт	л	144	
3	Металл авалт	%	95	
4	Цахилгаан хөдөлгүүрийн чадал	кВт	44.5	
5	1м3 уулын цулыг угаахад шаардагдах ус	м ³	2.2- 3.2	
6	Усны насосын марк	Vickers V2020-1F12S7S-1CC-30		
7	Хөдөлгүүр	Detroit D704 LE		
8	Конвейерийн татлага тросс	13мм бэхжүүлсэн төмөр тросс		
9	Конвейерийн дамжуурга	750 мм өргөн 3 давхар резин		
10	Конвейерийн урт	14м		

Хүснэгт №5. NZMS80BE маркийн скрубберын техникийн үзүүлэлт



Зураг №7. Элс угаалт



Зураг №8. Гүйцээн баяжуулалт

3.2. Шлюзэн дээрхи баяжуулалт

-20мм хүртэлх мөхлөг бүхий булинга шлюзэд орж баяжигдах бөгөөд баяжмалын металл авалт нь шлюзэнд орж буй бүтээгдэхүүний шингэн хатуугийн харьцаа, шлюзын налууугийн өнцөг, өгөгдөж буй усны урсгалын хурд, алтны ширхэгийн хэмжээ, элсэнд дэх металлын агуулга зэргээс хамаарна. Шлюзэн дээр алт ялган авах процесс нь эрдсийн мөхлөгүүд усанд унах чөлөөт уналтын хурд дээр үндэслэгддэг. Булинга хэт шингэрвэл үелэн хуваагдаж алтны хуваарилалтад сөрөг нөлөө үзүүлнэ.

Иймд тус төхөөрөмж хариуцсан мастер болон холбогдох техникийн ажилтан байнгын

хяналт тавьж ажилласан.

№	Төхөөрөмжийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон утга
1	Хүчин чадал	м ³ /ц	50-90
2	Шлюзны урт	мм	2500
3	Шлюзны өргөн	мм	2200
4	Шлюзны налуугийн өнцөг	°	10°~12°

Хүснэгт №6. Шлюзны техникийн үзүүлэлт



Зураг №9. NZMS80BE скрубберийн шлюз

3.3. Гүйцээн баяжуулах дамжлага

Анхан шатны баяжуулалтын технологиор ялгасан баяжмалыг гүйцээн баяжуулах цехэд боловсруулсан.

Шлюзээс авсан баяжмалыг жижиг бутаар ашиглан гүйцээн баяжуулсан ба баяжигдсан баяжмалыг гар соронзоор татуулах замаар эцсийн бүтээгдэхүүн болгосон.

ДӨРӨВ. УУРХАЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖ

Уурхайн цахилгааны хэрэглэгч нь усны насос, угаах төхөөрөмж, гагнуурын аппарат болон гал тогоо, гэрэлтүүлэг г.м бусад жижиг хэрэглэгчид байна. Уурхайн ажиллах хугацаа богино, цахилгаан эх үүсвэр байхгүй уурхайн цахилгааны хэрэгцээг дизель станцаар хангасан.

Ил уурхайн уулын ажил явагдах нийт ажлын талбай, үйлдвэр, цехийн байр, ажиллаж байгаа машин техникийн ойр орчим, ажилчдын байнга явах зам зэрэг талбайг харанхуй үед зайлшгүй гэрэлтүүлж байлаа. Шаардлагатай тохиолдолд зөөврийн жижиг прожектороор гэрэлтүүлнэ. Уурхайн тосгоны гадна талбайг 1 ш прожектороор гэрэлтүүлж байсан.

ТАВ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Бидний үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг дараахь хүснэгтэд үзүүлэв.

“Байдрагийн цагаан тохой” нэртэй MV-004960 тусгай зөвшөөрөлтэй алтны шороон орд нь Баянхонгор аймгийн Бөмбөгөр сум, Бууцагаан сумын нутагт оршино. Тус ордууд нь Улаанбаатар хотоос 750 км, Баянхонгор сумын баруун хойно 130 км, Бөмбөгөр сумын төвөөс баруун хойно 28 км, Бууцагаан сумын төвөөс зүүн хойно 60 км зайд байрлана.

Төслийн байршлаас үзүүлэх нөлөөллийн үнэлгээний 5 үзүүлэлтээр авч үзлээ.

Нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд	Нөлөөллийн эрчим			
	Бага	Дунд	Их	Хүчтэй
Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх	X			
Хүний нөлөө болон байгаль, цаг уурын өөрчлөлтөд эмзэг, эсэх		X		
Орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байгаа эсэх	X			
Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсэх эсэх		X		
Хуулиар хамгаалсан нутгийн хилийн цэсэнд хамааралтай эсэх		X		
ийн байршлаас үзүүлэх нөлөөллийг 5 үзүүлэлтээр үнэлж үзэхэд 60% нь дунд зэрэг, 40% нь бага сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна. Төслийн байршилаас шалтгаалан үүсэх сөрөг нөлөөллийн эрчим ДУНД байна.				

Хүснэгт №7. Төслийн байршилаас шалтгаалан үүсэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

5.1. Газрын гадаргад нөлөөлөх гол сөрөг нөлөөлөл

Төслийн талбай нь монгол орны физик газарзүйн мужлалаар Хангайн нурууны өвөр хэсэгт Байдраг голын савд оршино. Далайн түвшнээс дээш дунджаар 1600-2000 м өргөгдсөн. Уулт хээрийн бүсэд багтдаг.

Уурхайн үйлдвэрийн талбай, зам, тосгон, овоолго, баяжуулах хэсэг зэрэг объектуудад үйл ажиллагаа явагдаж тодорхой хэмжээгээр эвдрэл үүснэ. MNS 5915:2008 стандартын дагуу эвдэрсэн газрын ангилалыг дараах хүснэгтэд үзүүлэв.

д/д	Эвдэрсэн газрын бүлэг	Хэмжээ	Нэгж	Эвдрэлийн шинж
Эвдрэлд өртөх талбай				
1	Тосгон	1	Га	Уурхайн тосгоны талбай
2	Уурхайн технологийн зам	0.47	Га	Авто зам
3	Олборлолтод өртсөн талбай	1.9	Га	Уурхайн ухаш
	Нийт	3.37	Га	

Хүснэгт №8. Уурхайн ашиглалтаар эвдрэлд орсон талбайн ангилал

№	Болзошгүй нөлөөлөл	Үр дагавар
---	--------------------	------------

		Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Аюултай
1	Уурхайн ашиглалтын талбай				х	
2	Газрын хэвлийд үүсэх хоосон орон зай		х			
3	Шимт хөрсний овоолго			х		
4	Уурхайн барилга байгууламж барих талбай		х			
5	Тээвэрлэлт хийх зам			х		
	Нийт		2	2	1	
	Эзлэх хувь, %		40%	40%	20%	
Дүгнэлт - Нийт нөлөөллийн 20% нь их, 40% нь дунд, 40% нь бага гэсэн ангилалд багтаж байгаа алт олборлох төслөөс тухайн нутгийн газрын гадарга, хэвлийд нөлөөлөх нөлөөллийн зэргийг ДУНД гэж дүнэж байна.						

Хүснэгт №9. Төслөөс газрын гадарга, хэвлийд нөлөөлөх байдлын үнэлгээ

5.2. Агаарын чанарт нөлөөлөх гол сөрөг нөлөөлөл

Алтны шороон ордыг ашиглах үед хөрс хуулах, алт олборлох болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд өртсөн ухлага, овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос шороо агаар орчныг байнга бохирдуулдаг бөгөөд тэр нь салхины хурд, агаарын чийгшил болон хуурайшилт зэргээс шалтгаалан жилийн дөрвөн улиралд харилцан адилгүй байдаг.

Уул уурхайн үйлдвэрлэлд ялангуяа алтны аж ахуйд тухайн бичил орчны ба нутаг орны салхины ерөнхий горим ихээхэн нөлөөтэй байдаг. Салхины зонхилох чиглэлийн давтагдал, хурд, цасан ба шороон шуурга, хүчтэй салхи, салхины ачаалал нь технологийн хэм хэмжээг тодорхойлох, байгаль орчинд тоос шорооны бохирдол тархах гол хүчин зүйл болдог.

Энэ бичил хэсэгт салхины үндсэн чиглэлийн нөлөө бас бий. Тухайлбал хөндий дагасан өглөө оройны салхинаас гадна олборлолтын үед баруун хойд, хойд зүгээс голлон салхилна. Салхины хамгийн их хурд хавар, шороон шуургатай өдрийн тоо 25 байдаг ба энд салхины хурд 3.4-4.1 м/с хүрэх үеэс шороон шуурга байнга тохиолдох боломжтой байна. Алт олборлох хугацаа нь 5 дугаар сарын 1-ээс 10 дугаар сарын 29 хүртэл байх ба энэ хугацаанд салхины дундаж хурд 1.7-4.1 м/с, шороон шуургатай өдрийн тоо 15 байна.

Энэ нь агаарын тоосжилтын бохирдлыг ихэсгэнэ. Өөрөөр хэлбэл салхины чиглэл, хурднаас хамаарч ялангуяа намар ба хаврын цаг агаарын хуурайшилттай саруудад хөрс хуулалт, овоолго хийх ажлын үед их хэмжээний тоос шороо гарч агаар орчны бохирдол ихсэх магадлалтай байна. Иймд хамгаалах маск, баг зэргийг үл хэрэглэснээс уурхайчид болон механикжуулагчид бронхит, селикоз зэрэг уушигны өвчнөөр өвчлөх нөлөөлөл үүсэж болзошгүй юм.

Овоолго шороог удаан байлгах нь шороо хийсэх, орчныг тоосжуулах нөхцөл болох учир

агаарын тоосжилтыг багасгах өөр нэг арга бол уурхайн орчны эвдрэлд орсон газрыг услаж чийглэж байхаас гадна аль болох богино хугацаанд нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэж байх нь чухал байна.

Уурхайд ашиглагдах үндсэн машин механизмуудын үйл ажиллагааны үед үүсэх тоосны хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

№	Тоног төхөөрөмжүүд	Тоосны хэмжээ, мг/с	
		Тоос багасгах арга хэмжээ аваагүй үед	Тоос багасгах арга хэмжээ авсан үед
1	Экскаватор	100-150	30-50
2	Автосамосвал	2500	140
3	Бульдозер	300	80

Хүснэгт №10. Төхөөрөмжүүдийн үйл ажиллагааны үед үүсэх тоосны хэмжээ

Тоос хийсэх процесс цагт 18.86 кг/цаг буюу хоногийн 5 цагт үргэлжилнэ гэж үзвэл хоногт 94.3 кг/хон, уурхайн ашиглалтын хугацаанд /180 хоног/ 15 хоног нь салхи шуургатай байна гэвэл уурхайн задгай талбайгаас жилдээ 1.41тн, уурхай ашиглалтын 4 жилийн хугацаанд 5.64тн шороо салхинд хийсэх юм.

Энэ хэмжээ нь уурхайн эдэлбэр газрыг нийтэд нь нөхөн сэргээлт хийлгүй хөрс хуулалт явуулж олборлоно гэж үзэхэд гарах ойролцоо хэмжээ болно. Энэ нь тоосжилтын түвшний үнэлгээгээр дунд зэрэг буюу зарим тохиолдолд бохир гэсэн ангилалд оруулж болохоор байна. Иймд тоосжилтын нөлөөллийг бууруулах, ялангуяа уурхай орчмын ухлага, овоолгод өртсөн газар, тээврийн замыг услах замаар байгаль орчин, ажиллагсдыг энэхүү нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг авч явуулах нь зүйтэй юм. Цаг уурын хуурайшилттай намрын улиралд уурхайн овоолго, автозам зэргийг зориулалтын усалгааны машинаар заавал услаж байх нь зүйтэй.

№	Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Хүчтэй
1	Олборлолтын технологийн процессийн явцад тоос ихээр гарч агаарт дэгдэгдэх				Х
2	Олборлох, тээвэрлэх, буулгах явцад тоосжилт үүсэх, салхины хурд нэмэгдэх, шороон шуургатай үед тоосжилт нэмэгдэх			Х	
3	Олборлолтын үйл ажиллагааны туршид ашиглагдах тээврийн хэрэгсэл, хүнд даацын машин механизмуудаас нүүрстөрөгчийн дутуу исэл (СО), нүүрстөрөгчийн давхар исэл (СО ₂), азотын ислүүд (NO _x), хүхрийн оксид (SO _x) болон тоосжилт ялгарах			Х	
4	Машин механизм, техник хэрэгслээс гарах дуу чимээ, хорт хийнүүд ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх		Х		
Нийт нөлөөллийн 50% нь их, 25% нь хүчтэй, 25% нь дунд гэсэн үнэлгээтэй байгаа нь агаарт үзүүлэх сөрөг нөлөөлөл ИХ байгааг харуулж байна.					

Хүснэгт №11. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

5.3. Усан орчинд нөлөөлөх гол сөрөг нөлөөлөл

Уурхай болон үйлдвэр технологийн хэрэгцээний усыг гадаргын ус болон хөрсний шүүрлийн усаар хангана. Энэ тохиолдолд газрын гадаргын болон гүний усны нөөцөд тодорхой хэмжээний хомсдол үүсгэх болно. Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал хөрсийг бохирдуулснаас гадаргын болон гүний усанд шууд бусаар нөлөөлнө.

№	Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Хүчтэй
1	Төслийн үйл ажиллагаагаар гадаргын усан сүлжээ өөрчлөгдөх	X			
2	Олборлолтын үйл ажиллагааны улмаас төслийн талбай, түүний ойр орчмын нутаг дэвсгэрийн газар доорхи усны нөөц хомсдох			X	
3	Газар доорхи усны баланс алдагдах, химийн найрлага нь өөрчлөгдөж бохирдох	X			
4	Гадаргын болон газрын доорхи уст үеүд шатах тослох материал, хог хаягдал ахуйн болон бусад замаар бохирдох	X			
Нийт нөлөөллийн 25% нь их, 75% нь бага үнэлгээтэй байгаа нь усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл зэргийн нөлөөлөл үзүүлэхийг харуулж байна.					ДУНД

Хүснэгт №12. Усанд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

Түлш шатахуун, шатах тослох материалууд, бохир ус алдагдсан тохиолдолд гүний ус шууд бохирдож хөрсөөр дамжин хөрс, хүн, мал амьтан, ургамалд сөргөөр нөлөөлнө.

Газрын тосны бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хүлээн авах, хадгалах, түгээх үйл ажиллагааны үед технологийн болон техникийн осол, гэмтэл хүний санамсаргүй үйл ажиллагаанаас үүдэн шатахуун алдагдах явцад хөрсөнд шүүрэлт, нэвчилт явагдаж хөрс, хөрсний ус бохирддог. Хөрсөнд газрын тосны бүтээгдэхүүн их хэмжээгээр, эсвэл удаан хугацааны туршид алдагдвал хөрсний ялзмагийн хэмжээ багасаж, ургамлын өсөлт зогсон, хөрсний үржил шим бүрэн алдагдаж ургамал, бичил биет, амьтан хордох, идэш тэжээлийн хомсдол бий болох, устах сөрөг үр дагавартай байдаг.

Газрын тосны бүтээгдэхүүн хөрсөнд нэвчих ерөнхий хэлбэр нь гадаргууд перпендикуляр чиглэлд хамгийн их (радиал хэлбэрээр), бусад чиглэлд харьцангуй бага байх бөгөөд газрын тосны бүтээгдэхүүний төрөл, хөрсний бүтцээс хамааран нэвчилтийн хурд, тархах хүрээ янз бүр байна. Газар доорхи усанд газрын тосны бүтээгдэхүүн алдагдвал удаан хугацаагаар хадгалагдаж, хүхрийн оксид үүсгэн усыг идэмхий шинж чанартай болгон, газар доорх усны тархалтын талбайг хамарсан бохирдол үүсэж усан дахь хүчилтөрөгчтэй нэгдэн давирхайлаг бодис үүсгэн хар тугалга, хүнд металлын байнгын бохирдлын эх үүсгэврийг бий болгоно. Бохирдол нь газар доорх усны шилжилтийн дагуу тархаж, хүрээгээ тэлэх ба бүрэн цэвэрших боломжгүй.

5.4. Ургамлан нөмрөгт нөлөөлөх гол сөрөг нөлөөлөл

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны нөлөөгөөр хөрсөнд шүлтлэг металлын агууламж нэмэгдэж, хөрсний кали, фосфорын элементүүд багасаж улмаар бүрхүүлд нөлөөлж ургамал эрт хагдрах, хөрс элэгдэх үндсэн шалтгаан болдог. Судалгаанаас үзвэл газарт бууж буй тоос нь ургамлын аль нэг хэсэгт наалдаж улмаар өнгө зүс нь алдагдах, навч шилмүүсэнд нь түлэгдэлт үүсэх, навч нь эрт унах зэрэг байдал бий болдог байна.

№	Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Хүчтэй
1	Бэлчээрийн ургамал уурхайн овоолго шороо, хог хаягдлын байгууламж, үйлдвэрийн барилга байгууламж барьж байгуулсны улмаас устаж ойр орчимд нь талхлагдал үүсэх			х	
2	Машин техникийн хөдөлгөөн, овоолго шороо болон хог хаягдал зэрэг төслийн үйл ажиллагааны нөлөөлөл, үр дагаврын улмаас одоо байгаа ургамлын үржил хөгжил саатах, улмаар мөхөх зэргээр ашиглалтын талбай орчимд урт удаан хугацааны доройтол үүсэх			х	
3	Ашиглалтад өртөх 3.37 га талбайн ургамлан нөмрөг бүхэлдээ устаж үгүй болно.				х
Нийт нөлөөллийн 25% нь хүчтэй, 75% нь их гэсэн үнэлгээтэй байгаа нь ургамалд үзүүлэх сөрөг нөлөөлөл ИХ байгааг харуулж байна					

Хүснэгт №13. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

5.5. Амьтаны аймагт нөлөөлөх гол сөрөг нөлөөлөл

Төслөөс амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь дараах хүчин зүйлсээр тодорхойлогдоно. Үүнд:

- Техникийн осол аваар
- Хог хаягдал, ариун цэвэр бохирын асуудлыг сайтар төлөвлөхгүй бол хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор гэгдэх амьтны зүйлүүдийн тоо өсөх магадлалтай.

№	Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Хүчтэй
1	Бэлчээрийн ургамал уурхайн овоолго шороо, хог хаягдлын байгууламж, үйлдвэрийн барилга байгууламж барьж байгуулсны улмаас устаж ойр орчимд нь талхлагдал үүсэх			х	
2	Машин техникийн хөдөлгөөн, овоолго шороо болон хог хаягдал зэрэг төслийн үйл ажиллагааны нөлөөлөл, үр дагаврын улмаас одоо байгаа ургамлын үржил хөгжил саатах, улмаар мөхөх зэргээр ашиглалтын талбай орчимд урт удаан хугацааны доройтол үүсэх			х	
3	Ашиглалтад өртөх 3.37 га талбайн ургамлан нөмрөг бүхэлдээ устаж үгүй болно.				х

Нийт нөлөөллийн 25% нь хүчтэй, 75% нь их гэсэн үнэлгээтэй байгаа нь ургамалд үзүүлэх сөрөг нөлөөлөл ИХ байгааг харуулж байна

Хүснэгт №14. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

Олборлолтын үйл ажиллагааны улмаас амьтдын амьдрах орчин устгах, жижиг амьтад үйл ажиллагаанд өртөж үхэж хорогдох, хүний үйл ажиллагааны улмаас амьтдын бүлгэмдэлд өөрчлөлт орох, улмаар зарим зүйл амьтдын тоо толгой, цөөрөх, нүүдэл шилжилтэнд сөргөөр нөлөөлөх зэрэг сөрөг нөлөөтэй.

ЗУРГАА. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгахын тулд дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

Бид усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөж, олборлолтын үйл ажиллагаа явуулах хугацаандаа замын тоос шороог багасгах, олон салаа зам гарахаас сэргийлэх зорилгоор уурхайн карьераас кемп хүртэлх замыг түрж тэгшлэн тогтмол усалгааг хийж гүйцэтгэн тээврийн хэрэгслийн хурдны дээд хязгаарыг харуулсан тэмдэг тэмдэглэгээг байршуулсан.

Усны нөөцийг бохирдуулахгүй байх үүднээс ахуйн хэрэглээнээс гарах хаягдал усыг хуримтлуулах септик танкийг суурилуулсан.



Зураг №10. Хог хаягдлыг хуримтлуулах сав

№	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Нийт 2022 оны зардал /мян.төг/	Биелэлт	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
1. АГААР ОРЧИН ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ					
	Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: -Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, овоолго зэрэг газар шорооны ажил, -Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, -Тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох	Хурдны заалтын тэмдэг тэмдэглэгээ тавих Уурхайн дотоод зам болон кемп уурхайн карьер хоорондын замыг услах	350.0	Тоосжилтыг дарах зорилгоор уурхайн кемп хүртэлх замд 20км/ц, 10км/ц, 5км/ц, хурдны хязгаар заасан тэмдэгүүдийг байршуулсан. Уурхайн дотоод зам болон кемп уурхайн карьер хоорондын замыг өдөрт нэг удаа тогтмол услаж байсан.	Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003
Нийт дүн			350.0		
2. ХӨРСӨН БҮРХЭВЧ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ					
		Нөхөн дүүргэлтийг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх	Үйл ажиллагааны зардалд орсон	Олборлолтын системтэй холбоотойгоор нөхөн сэргээлтийн зардлыг олборлолтын зардалд оруулан тооцдог.	MNS 5915:2008
	Ордын ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх.	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх		Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг Геодата ХХК-аар гүйцэтгүүлсэн.	Газрын тухай хуулийн 58-р зүйл
		Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	200,0	ХАБ болон БО мэргэжилтэн ажилчидад, жолооч нарт сургалт явуулсан.	

Талбай доторх ургамлан нөмрөг устаж үгүй болох сөрөг нөлөөтэй	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг Баянхонгор аймгийн БО ны мэргэжилтийн зааж өгсөн газарт хийсэн		Бөмбөгөр сумын ЗДТГ болон Баянхонгор аймгийн Байгаль орчин аялал жуулчлан газраас манайд албан бичгээр хүсэлт тавьсан ба компаний удирдлагад танилцуулж зөвшөөрсөн тул Бөмбөгөр суманд байгуулж буй ногоон байгууламжийн ойролцоо зааж өгсөн газарт 500 ширхэг улиасны суулгац суулгаж хамгаалтын төмөр хашаагаар хашаалж усалгаа хийж сумын удирдлагад хүлээлгэн өгсөн.	БОНХСайдын 2014 оны А-117 тушаал	
Шатах тослох материал, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Шатахуун асгарч хөрсрүү нэвчихээс сэргийлж ШТМ хадгалах хэсэгт хөрсрүү бохирдол үл нэвчүүлэх мембран фильтр дэвсэх	120,0	мембран фильтр дэвссэн.		
Нийт дүн		320,0			
3.УСНЫ НӨӨЦ, ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ					
Гүний усыг ашигласнаар усны нөөц хомсдох, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамжилтад сөргөөр нөлөөлж болзошгүй.	Байдраг голоос сард нэг удаа дээж авч шинжилгээнд хамруулж усны чанарт хяналт тавих	100	Олборлолтын хугацаанд нийт 1 удаа усны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль MNS 4288:1995	
